



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 05 сарын 24 өдөр

Дугаар A/48

Мандалговь

**Залуучуудын хөгжлийн зөвлөл
байгуулах тухай**

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 13 дугаар зүйл, 14 дүгээр зүйл, Засгийн газрын 2019 оны 171 дүгээр тогтоолоор батлагдсан "Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөр"-ийн 5.2.8 дахь заалт, Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн 2021 оны 01 дүгээр тогтоол, "Залуучуудын хөгжлийн зөвлөлийн үлгэрчилсэн дүрэм батлах тухай" Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/72 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Залуучуудын үзэл бодлыг сонсох, хүндэтгэх, хөгжил оролцоо, санал, санаачилгыг дэмжих болон тэдгээрийн эрхийг хангахад чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулах зорилгоор Залуучуудын хөгжлийн зөвлөлийг байгуулсугай.

2. Залуучуудын хөгжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг хамт олноос авсан саналыг үндэслэн хавсралтаар баталсугай.

3. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/72 дугаар тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Залуучуудын хөгжлийн зөвлөлийн үлгэрчилсэн дүрэм"-ийн хүрээнд зохион байгуулж ажиллахыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Залуучуудын хөгжлийн төвийн сургалт хариуцсан ажилтан, Залуучуудын хөгжлийн зөвлөлийн нарийн бичиг /Т.Насандэлгэр/-д даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтийг хангаж, жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хагас бүтэн жилээр тайлагнахыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Залуучуудын хөгжлийн төвийн сургалт хариуцсан ажилтан, Залуучуудын хөгжлийн зөвлөлийн нарийн бичиг /Т.Насандэлгэр/-д үүрэг болгосугай.


ДАРГА



Ц.ГАНЗОРИГ

480190095

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын даргын
2021 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн
1148 дугаар тушаалын 2 дүгээр хавсралт



АЙМГИЙН ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛ

Тэргүүн: Б.Жанчивдорж /Татварын улсын байцаагч/
Дэд тэргүүн: Р.Мөнхбат /ГБХЗХГ-ын ахлах мэргэжилтэн/
Нарийн бичгийн дарга: Т.Насандэлгэр /ЗХТ-ийн ажилтан/
Гишүүд:

П.Мөнхсүх /ХХАГ-ын ажилтан/
О.Уранзаяа / СЦсумын ЗДТГ-ын мэргэжилтэн/
Т.Саранчимэг /МХГ-ын мэргэжилтэн/
А.Мөнх-Эрдэнэ /БОАЖГ-ын мэргэжилтэн/
С.Намжилмаа /БСУГ-ын мэргэжилтэн/
Ш.Бямбасүх /ЦГ-ын хэв журамын ахлах байцаагч/
М.Ууганбат /НДХ-ийн мэргэжилтэн/
Д.Батсүрэн /БТСГ-ын дасгалжуулагч/
А.Энхбат /МСҮТ-ийн ахлах ажилтан/
Ц.Нацагдорж /ОБГ-ын бүлгийн ахлагч/
Ц.Ууганнасандорж /ШШГГ-ын мэргэжилтэн/
Н.Шижирболд /УБГ-ын мэргэжилтэн/
Э.Ган-очир /Статистикийн хэлтсийн мэргэжилтэн/
Э.Дашням /Ган-Илч ХХК-ийн ажилтан/
Б.Өнөрхүү /УЦУОШГ-ын ажилтан/
О.Мөнгөнхундага / НЭ-ийн ажилтан/
Б.Саруулцэцэг /ЭМГ-ын мэргэжилтэн/
Б.Отгонхүү / Цахилгаан түгээх ТӨҮГ-ын ажилтан/
Б.Энхзаяа /ТХДЖТ-ын дуучин/
Э.Үүрийнтуяа /Номын сангийн ажилтан/
Б.Адъяа /ЗДТГ-ын Гадаад харилцааны ажилтан/
Д.Хүрэлцоож /ХХҮГ-ын мэргэжилтэн/